



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2017 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А-316

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5, 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Бага дүнтэй төлбөрийн системийн журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн А-145 дугаар тушаал, 2016 оны 9 дүгээр 02-ны өдрийн А-236 дугаар тушаалын 1.1 дэх заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ журмыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), бага дүнтэй төлбөрийн системийн оролцогч нарт тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), Дотоод аудитын газар (Ж.Батхуяг)-т тус тус даалгасугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А-98

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн 6.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А-316 дугаар тушаалаар баталсан “Бага дүнтэй төлбөрийн системийн журам”-ын 10.2 дахь заалтад 10.2.3-10.2.5 дэд заалт нэмсүгэй:

10.2.3. Төлбөр хариуцагчийн гүйлгээнд хариу өгөх хугацаа дууссан (цаашид “time out” гэх) эсхүл ҮЦГТ-өөс 84 ба 91 хариу код авсан тохиолдолд төлбөр хариуцагчийн систем автоматаар буцаалтын гүйлгээг илгээнэ.

10.2.4. Төлбөр хариуцагчийн илгээж буй буцаалтын гүйлгээ “Time-out” болвол буцаалтыг дахин автоматаар илгээх бөгөөд илгээх тоо 3 (гурав)-аас хэтрэхгүй байна.

10.2.5. Буцаалтын гүйлгээний “Time-out” хугацаа эх гүйлгээний “Time-out” хугацаатай адил байна.

2. Энэ тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), бага дүнтэй төлбөрийн системийн оролцогч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т тус тус даалгасугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН

БАГА ДҮНТЭЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалтын дагуу төлбөрийн системийн оролцогч хоорондын бага дүнтэй төлбөрийг үнэн зөв, найдвартай, тасралтгүй шилжүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 ҮЦГТ болон бага дүнтэй төлбөрийн системд оролцогч нь энэхүү журмыг мөрдөнө.
- 1.3 Бага дүнтэй төлбөрийг шилжүүлэхтэй холбогдсон нууцлал, аюулгүй байдлын талаар баримтлах бодлогыг Монголбанк тогтоож, Үндэсний Цахим Гүйлгээний Төв /ҮЦГТ/ болон оролцогч хэрэгжүүлэн ажиллана.
- 1.4 Оролцогч нь Монголбанктай “Бага дүнтэй төлбөрийн системийн оролцогчтой байгуулах гэрээ”-г байгуулна. Энэхүү гэрээгээр Монголбанк болон оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагатай холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулна.

Хоёр. Нэр томьёо

Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

- 2.1 “Оролцогч” гэж “Үндэсний төлбөрийн системийн тухай” хуулийн 5.1.7-д заасан этгээдийг;
- 2.2 “Бага дүнтэй төлбөрийн систем” гэж энэ журмын 2.3-т заасан төлбөрийг гүйцэтгэх, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.2 дахь хэсэгт заасан цогц бүтцийг;
- 2.3 “Бага дүнтэй төлбөр” гэж Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтоосон хязгаараас бага буюу түүнтэй тэнцүү мөнгөн дүнтэй, төлбөрийн системийн оролцогч хооронд хийгдэж буй гүйлгээг;
- 2.4 "Гүйлгээ" гэж “Үндэсний төлбөрийн системийн тухай” хуулийн 5.1.18-т заасан шилжүүлгийн цахим хэлбэрийг;
- 2.5 “Банксүлжээ” систем гэж төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцоог гүйцэтгэж, үр дүнгийн тооцоог оролцогч тус бүрийн Монголбанк дахь харилцах дансанд тусгаж буй төлбөр тооцооны системийг;
- 2.6 “Гүйлгээ дамжуулах өдөр” гэж тухайн өдрийн 00:00 цагаас дараагийн өдрийн 00:00 цаг хүртэлх хугацааг;

- 2.7 “Бодит цагийн горим” гэж гүйлгээг цаг тухайд нь илгээх, дамжуулах, хүлээн авах горимыг;
- 2.8 "Буцаалтын гүйлгээ" гэж системийн алдааны улмаас амжилтгүй болсон гүйлгээг төлбөр хариуцагч руу буцаан илгээх гүйлгээг;
- 2.9 “Төлөвлөгөөт зогсолт” гэж ҮЦГТ болон оролцогч нь засвар, үйлчилгээ хийх зорилгоор ҮЦГТ болон бусад оролцогчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр өөрийн бага дүнтэй төлбөрийн системийн үйл ажиллагааг хэсэгчлэн болон бүрэн зогсоохыг;
- 2.10 “Гэнэтийн саатал” гэж бага дүнтэй төлбөрийн системийн үйл ажиллагаа 2 минутаас дээш хугацаагаар, төлөвлөгөөт бусаар хэсэгчлэн болон бүрэн зогсохыг;
- 2.11 “Нөөц төв” гэж ҮЦГТ, оролцогчийн мэдээллийн технологийн үндсэн төвд онцгой байдал үүсэх үед бага дүнтэй төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор байгуулсан мэдээллийн технологийн нөөц систем, түүний техник төхөөрөмжийн байгаа байршлыг;
- 2.12 “Төлбөр хариуцагч” гэж гүйлгээ илгээж буй оролцогчийг;
- 2.13 “Төлбөр хүлээн авагч” гэж гүйлгээ хүлээн авч буй оролцогчийг;
- 2.14 “ҮЦГТ” гэж Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийг;

Гурав. Оролцогчид тавигдах шаардлага

- 3.1 Бага дүнтэй төлбөрийн системд Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан зөвшөөрөл бүхий Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Ирээдүйн өв сан корпораци, Арилжааны төлбөр тооцооны төв болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв оролцоно.
- 3.2 Бага дүнтэй төлбөрийн системд оролцогч нь “Үндэсний төлбөрийн системийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 1 дэх заалтад заасан шаардлагаас гадна дор дурдсан шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллана:
 - 3.2.1 Монголбанкин дахь харилцах дансандаа үр дүнгийн тооцоолол хийж, үр дүнгийн төлбөр тооцоог тусгахад хүрэлцэхүйц хангалттай хэмжээний эх үүсвэртэй байх;
 - 3.2.2 Монголбанкаас тавьсан стандарт, техник тоног төхөөрөмж, сүлжээний холболтын шаардлагыг ханган ажилладаг байх;
 - 3.2.3 Системийн аюулгүй, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор “Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө” боловсруулж, мөрдөж ажиллах.
 - 3.2.4 Монголбанкнаас тавьсан бусад шаардлагыг ханган ажиллах.

Дөрөв. Оролцогчийн эрхийг түдгэлзүүлэх, зөвшөөрлийг хүчингүй болгох

- 4.1 Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийн дагуу оролцогчийн бага дүнтэй төлбөрийн системд оролцох эрхийг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 25.2 дахь хэсэг болон 41 дүгээр зүйлд заасны дагуу түдгэлзүүлнэ.
- 4.2 Системд оролцохыг хязгаарлах үндэслэл арилсан тохиолдолд Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр оролцогчийн эрхийг сэргээнэ.
- 4.3 Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийн дагуу “Үндэсний төлбөрийн системийн тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлийн 2-т заасан үндэслэлээр оролцогчийн төлбөрийн системд оролцох эрхийг хүчингүй болгоно.

Тав. Төлбөр гүйцэтгэх суурь зарчим

- 5.1 Бага дүнтэй төлбөрийг ҮЦГТ-өөр бодит цагийн горимд дамжуулан олон улсын санхүүгийн мэдээний ISO8583 стандартын дагуу гүйцэтгэнэ.
- 5.2 Оролцогчийн төв салбар нь ҮЦГТ-тэй байнгын холболттой байж, бага дүнтэй төлбөрийг тасралтгүй гүйцэтгэнэ.
- 5.3 Төлбөр хариуцагч нь төлбөрийн баримтыг цаасаар болон цахим хэлбэрээр холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу хадгална.

Зургаа. Төлбөр тооцоо, үр дүнгийн тооцоолол

- 6.1 ҮЦГТ болон оролцогч нь бага дүнтэй төлбөрийг гүйлгээ дамжуулах өдрийн турш бодит цагийн горимоор илгээж, хүлээн авна.
- 6.2 Төлбөр хүлээн авагч нь төлбөр хариуцагчид харилцагчийн дансны нэр, дугаар тохирч буй эсэхийг баталгаажуулж өгнө.
- 6.3 Төлбөр хариуцагч нь харилцагчийн дансны нэр, дугаар баталгаажсан тохиолдолд гүйлгээг илгээнэ.
- 6.4 Оролцогчийн төлбөр тооцоо хариуцсан ажилтан нь үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг дараагийн ажлын өдрийн 9:00 цагаас 11:00 цагийн хооронд ҮЦГТ-ийн ээлжийн оператортай тохируулна.
- 6.5 ҮЦГТ нь үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг дараагийн ажлын өдрийн 11:10 цагт “Банксүлжээ” систем рүү дамжуулна.
- 6.6 “Банксүлжээ” систем нь ҮЦГТ-өөс ирүүлсэн үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг оролцогч бүрийн Монголбанкны дахь харилцах дансанд тусгаж, өмнөх өдрийн бага дүнтэй төлбөр тооцоог эцэслэнэ.

- 6.7 Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн оролцогчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг тохируулах, дамжуулах талаар энэ журмын 6.4, 6.5-д болон холбогдох гэрээнд заасан хугацааг мөрдөхгүй байж болно.
- 6.8 Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн оролцогчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр үр дүнгийн тооцооллын хаалтын дүнгээр тухайн өдрийн гүйлгээг хязгаарлаж болно.

Долоо. Тасралтгүй, найдвартай ажиллагаа

- 7.1 ҮЦГТ болон оролцогч нь бага дүнтэй төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллана.
- 7.2 Оролцогч нь системийн тасралтгүй ажиллагаа, системийн аюулгүй байдлын талаар баримтлах бодлого, техникийн стандартыг боловсруулсан байна.
- 7.3 ҮЦГТ болон оролцогчийн гэнэтийн саатлын хэмжээ сард 0.1 хувиас¹ ихгүй байна.
- 7.4 ҮЦГТ болон оролцогчийн системийн төлөвлөгөөт зогсолтын нийт хугацаа нь хоёр долоо хоногт 1 цагаас илүүгүй байна.
- 7.5 ҮЦГТ болон оролцогч нь “Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу жилд 1 /нэг/-ээс доошгүй удаа системийнхээ үйл ажиллагааг тодорхой үе шаттайгаар туршина.

Найм. Нууцлал, аюулгүй байдал

- 8.1 ҮЦГТ рүү илгээсэн гүйлгээний нууцлал, аюулгүй байдлыг төлбөр хариуцагч, ҮЦГТ-өөс хүлээн авсан гүйлгээний нууцлал, аюулгүй байдлыг төлбөр хүлээн авагч тус тус бүрэн хариуцна.
- 8.2 ҮЦГТ нь бага дүнтэй төлбөрийн системээр дамжин хийгдэж байгаа гүйлгээний мэдээллийг “Үндэсний төлбөрийн системийн тухай хууль”-ийн 32 дугаар зүйлийн 1-т дурдсанаас бусад тохиолдолд, оролцогч нь байнга чандлан хадгална.
- 8.3 ҮЦГТ нь зөвхөн дараах мэдээллийг нийтэд ил тод болгож болно:
- 8.3.1 Бага дүнтэй төлбөрийн системээр дамжсан гүйлгээний нийт тоо, дүн зэрэг ерөнхий мэдээлэл,
- 8.3.2 Бага дүнтэй төлбөрийн системийн талаарх тайлбар мэдээлэл.

Ес. Гүйлгээний шимтгэл

- 9.1 Монголбанк нь “Монголбанкны үйлчилгээний шимтгэл, хураамжийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу шимтгэл тооцож, оролцогч бүрийн үр дүнгийн төлбөр

¹ Сард 0.1% нь 43.49 минут болно.

тооцоонд оруулан Монголбанкин дахь харилцах данснаас суутган авч, Монголбанкны “шимтгэлийн орлого” нэртэй дансанд төвлөрүүлнэ.

- 9.2 ҮЦГТ нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 33.1 дэх хэсэг, “Монголбанкны үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу гишүүнчлэлийн хөлс тооцож оролцогчдоос авна.

Арав. Маргаан шийдвэрлэх ерөнхий зарчим ба Буцаалтын гүйлгээ

- 10.1 Маргаан шийдвэрлэхэд дараах зарчмыг баримтална.

10.1.1 Бага дүнтэй төлбөрийн системтэй холбоотой үүссэн аливаа гомдол, маргааныг оролцогчид хэлэлцэн зөвшилцөх байдлаар шийдвэрлэнэ.

10.1.2 Оролцогч нь үүссэн маргааныг 10.1.1-т зааснаар шийдвэрлэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

- 10.2 Буцаалтын гүйлгээг хийхэд дараах зарчмыг баримтална.

10.2.1 Буцаалтын гүйлгээг зөвхөн системийн алдааны улмаас гүйлгээ амжилтгүй болсон үед хийх бөгөөд “Бага дүнтэй төлбөрийн системийн оролцогчтой байгуулах гэрээ”-гээр нарийвчлан зохицуулна.

10.2.2 “Бага дүнтэй төлбөрийн системийн оролцогчтой байгуулах гэрээ”-нд зааснаас бусад тохиолдолд буцаалтын гүйлгээ хийхийг хориглоно.

10.2.3 Төлбөр хариуцагчийн гүйлгээнд хариу өгөх хугацаа дууссан (цаашид “time out” гэх) эсхүл ҮЦГТ-өөс 84 ба 91 хариу код авсан тохиолдолд төлбөр хариуцагчийн систем автоматаар буцаалтын гүйлгээг илгээнэ.

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А-78 дугаар тушаалаар нэмсэн/](#)

10.2.4 Төлбөр хариуцагчийн илгээж буй буцаалтын гүйлгээ “Time-out” болвол буцаалтыг дахин автоматаар илгээх бөгөөд илгээх тоо 3 (гурав)-аас хэтрэхгүй байна.

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А-78 дугаар тушаалаар нэмсэн/](#)

10.2.5 Буцаалтын гүйлгээний “Time-out” хугацаа эх гүйлгээний “Time-out” хугацаатай адил байна.

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А-78 дугаар тушаалаар нэмсэн/](#)

Арван нэг. Хяналт, хариуцлага

- 11.1 Энэ журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол буруутай этгээдэд Монголбанкнаас дараах арга хэмжээг авна.

11.1 Бага дүнтэй төлбөр тооцоог холбогдох журам, гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй бол холбогдох этгээдэд Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Банкны тухай, Банк, эрх бүхий

хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

11.1.2 Энэхүү журмыг хэрэгжүүлэх талаар Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийг биелүүлээгүй ажилтан, албан тушаалтныг холбогдох хууль тогтоомж болон Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

11.2 Монголбанкны хянан шалгагч нь энэ журмын 7.3-т заасан шаардлагыг хангаагүй оролцогчид энэ журмын 11.1 дэх хэсэгт заасан холбогдох хариуцлага хүлээлгэнэ.

11.3 Бага дүнтэй төлбөрийн системтэй холбоотой санал, гомдлыг Монголбанкны Төлбөр тооцооны асуудал эрхэлсэн газарт ирүүлж болно.

_____оОо_____